МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**
14193 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их тойруу 81/1, Утас/Факс: (976-11) 35 00 60,
И-мэйл: info@customs.gov.mn, Вэбсайт: www.customs.gov.mn

2021.07.30 № 01/1862

танай ____________-ны №____________-т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮН, САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН ТАНАА

Төсвийн төслийн санал хүргүүлэх
тухай

Гаалийн байгууллага нь ирэх онд гаалийн шинэчлэлийг үргэлжүүлж, хилийн боомтын нэвтрүүлэх, хяналт тавих хүчин чадлыг сайжруулах, уул уурхайн бүтээгдэхүүн болон импортын барааны чанар, агуулга, тоо хэмжээг шуурхай нарийвчлан тодорхойлж, татварыг ногдуулах, хяналт тавих, гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг түргэн, шуурхай, чирэгдэл багатай болгох, гаалийн харилцаанд оролцогчдод үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлэн олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэн ажиллахаар зорилт тавьж Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын дагуу 2022 оны урсгал болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсвийн төслийн саналыг боловсрууллаа.

Тус төсвийн төслийн саналд дараах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж, урсгал төсвийг тооцон тусгалаа. Үүнд:

1. Гаалийн зарим хилийн боомтуудыг /Булган, Бичигт, Ханх, Цагааннуур, Ульханмайхан/ шилэн кабельд холбох;

2. Дархан-уул аймгийн Гаалийн газарт төмрийн хүдэр, баяжмал, нефть, химийн бодис шинжлэх гаалийн салбар лаборатори шинээр байгуулах;

3. Оюутолгой гаалийн хяналтын бүсэд ажиллаж буй гаалийн байгууллагын албан хаагчдын орон сууцыг Өмнөговь аймгийн Ханбогд сумын төвд шинээр барих;

4. Хилийн боомтууд болон гүний гаальд ажиллаж буй албан хаагчдын зарим орон сууцыг шинэчлэх;

5. Замын-Үүд хилийн боомтод Хаан банкны балансад бүртгэлтэй барилгын хэсгийг худалдан авч салбар лабораторийг өргөтгөх; /Хилийн мэргэжлийн хяналтын лабораторитой холбоотой/;

6. 2023-2024 ондууд шинээр баригдах барилга байгууламжуудын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зардал;

7. Зарим хилийн боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангах зайлшгүй шаардлагатай барилга байгууламжийн их засварын зардал;

8. Гаалийн шинэчлэлийн хүрээнд 2019 оноос хэрэгжүүлж буй гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжүүд /нүүрснээс дээж авч шинжлэх төхөөрөмж, Рентгэн төхөөрөмж, Ухаалаг гарц иж бүрдэл төхөөрөмж/ нь коронавирусын цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан үйлдвэрлэлт, нийлүүлэлт, угсралт, суурилуулалтын ажил хойшлогдсон, мөн БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Замын-Үүд, Гашуунсухайт, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Алтанбулаг, Боршоо, Бичигт хилийн боомтуудын бүтээн байгуулалтын ажил төлөвлөсөн хугацаанаас хойшлогдож байгаа зэргээс шалтгаалан 2021 онд дээрх тоног төхөөрөмжүүд бүрэн нийлүүлэх боломжгүй болсон тул ирэх оны төсөвт тусгасан;

1439508 0941

9. Гаалийн газар, хороодын албан хаагчдыг хилийн боомт руу зөөвөрлөх, хилийн боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой техник хэрэгслүүд нь ашиглалтын шаардлага хангахгүй, замын хөдөлгөөнт оролцох боломжгүй байдалтай байгаа тул зайлшгүй шаардлагатай 19 тээврийн хэрэгслийг шинэчлэх;

10. БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Замын-Үүд, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Алтанбулаг, Сүхбаатар, Боршоо боомтуудын бүтээн байгуулалтын ажлуудын зарим хэсэг нь 2022 онд ашиглалтад орохтой холбоотой барилга байгууламжуудын урсгал болон байр ашиглалтын зардал, гаалийн хяналтын шалгалтын дээж авах төхөөрөмжүүд, рентгэн төхөөрөмжүүдийг ажиллуулах инженер техникийн алба, салбар лабораториуд, Эрэлч нохойн албыг бэхжүүлэх зэрэгт нийт 300 орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байгааг тооцож тусгасан;

11. Хөшигийн хөндий дэх Хил хяналтын байгууллагуудын Нэг цэгийн үйлчилгээний барилга, байгууламжууд ашиглалтад орох тул байр ашиглалтын болон урсгал зардал;

12. Гаалийн мэдээллийн нэгдсэн системийн шинэчлэлийн хүрээнд Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлэн худалдан авсан тоног төхөөрөмж, программ хангамжийн албан ёсны ашиглалтын эрх бүхий лицензийн төлбөр;

13. Байгууллагын дотоод үйл ажиллагааны болон албан хэрэг хөтлөлтийг сайжруулах зорилгоор программ хангамжийн албан ёсны ашиглалтын эрх бүхий лицензийн төлбөр;

14. Гаалийн лабораторийг олон улсын итгэмжлэлд хамруулах олон улсын зөвлөх үйлчилгээний багтай 2020 онд гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд коронавирусын цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан гаалийн төв лаборатори, салбар лабораторийн барилгууд хугацаа хоцорч ашиглалтад орсон, мөн тоног төхөөрөмжүүдийн нийлүүлэлтийн хугацаа хойшлогдсон зэргээс шалтгаалан олон улсын зөвлөх үйлчилгээний багийн төлөвлөсөн ажил хойшлогдож, гэрээ сунгагдахаар болж байгаа тул зөвлөх үйлчилгээний төлбөрийг тусгасан;

15. Ирэх онд Гаалийн лаборатори нь олон улсын зөвлөх үйлчилгээний багтай хамтран эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр БНХАУ-ын CNAS олон улсын итгэмжлэлд хамрагдах тул итгэмжлэлийн тэмдэг хэрэглэх жилийн хураамж, мөн зэс, молибдений шинжилгээний чиглэлээр Лондонгийн металлын биржид бүртгэлтэй дээжлэгч гишүүнээр элссэний хураамжийг төлж эхлэхтэй холбоотой гарах зардал;

16. Байгууллагын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж байгууллага хооронд гэрээ байгуулах, зохион байгуулах уулзалт, сургалтын арга хэмжээг тооцон тусгалаа.

Иймд нийт 82,9 тэрбум төгрөгийн урсгал төсөв, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 131,2 тэрбум төгрөг шаардлагатай байгаа тул манай төсвийн төслийн саналыг судлан үзэж, шийдвэрлэж өгнө үү.

Хавсралт хуудастай.

ДАРГА Б.АСРАЛТ

## Гаалийн байгууллагын 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөлөл

(мян төг)

| Код | Үндсэн үйл ажиллагаа | Гүйцэтгэл .1. 2020 Гүйцэтгэл | Гүйцэтгэл .2. 2021 ХБГ | Санал .3. 2022 Хяз.бат | Санал .4. 2022 ТЕЗ санал | Төсөөлөл .5. 2023 төсөөлөл | Төсөөлөл .6. 2024 төсөөлөл | Өөрчлөлт .7. 2020 гүйц 2021 ХБГ | Өөрчлөлт .8. 2021 бат 2022 хяз | Өөрчлөлт .9. 2022 хяз 2022 сан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **А. Зардлын эдийн засгийн зүйлс** | | | | | | | | | | |
| 2101 | Цалин хөлс болон урамшил | 24,891,187.7 | 31,962,923.4 | 31,962,923.4 | 45,976,829.6 | 59,769,878.5 | 77,700,842.1 | 77.9 | 100.0 | 69.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх | 3,199,551.9 | 4,150,037.1 | 4,150,037.1 | 6,666,640.3 | 8,666,632.4 | 11,266,622.1 | 77.1 | 100.0 | 62.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2,254,952.4 | 4,618,098.8 | 4,618,098.8 | 4,573,192.8 | 5,945,150.7 | 7,728,695.9 | 48.8 | 100.0 | 101.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 819,598.7 | 869,720.4 | 869,720.4 | 1,800,299.9 | 2,340,389.9 | 3,042,506.8 | 94.2 | 100.0 | 48.3 |
| 2105 | Нормативт зардал | 832,492.3 | 1,367,410.3 | 1,367,410.3 | 2,785,800.0 | 3,621,540.0 | 4,708,002.0 | 60.9 | 100.0 | 49.1 |
| 2106 | Эд хогшил, урсгал зардал | 4,208,114.2 | 6,374,960.5 | 6,374,960.5 | 6,173,010.8 | 8,024,914.0 | 10,432,388.3 | 66.0 | 100.0 | 103.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 80,908.5 | 187,272.5 | 187,272.5 | 439,333.4 | 571,133.4 | 742,473.4 | 86.3 | 100.0 | 42.6 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн АҮТХ | 5,155,658.6 | 3,090,824.5 | 3,090,824.5 | 7,005,859.3 | 9,107,617.0 | 11,839,902.1 | 166.8 | 100.0 | 44.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,545,966.9 | 1,599,512.8 | 1,599,512.8 | 3,587,735.1 | 4,664,055.6 | 6,063,272.3 | 96.7 | 100.0 | 44.6 |
| 212 | Татаас | | | | | | | | | |
| 213 | Урсгал шилжүүлэг | 1,057,723.0 | 771,966.0 | 158,895.7 | 3,918,300.0 | 5,093,790.0 | 6,621,927.0 | 137.0 | 485.8 | 4.1 |
| 22 | Хөрөнгийн зардал | | | | | | | | | |
| ## | Бусад | | | | | | | | | |
| **НИЙТ, Зардлын зүйл*** | | MNT 44,046,154.2 | MNT 54,992,726.3 | MNT 54,379,656.0 | MNT 82,927,001.2 | MNT 107,805,101.6 | MNT 140,146,632.0 | | | |
| **Б. Зардлын зориулалт-арга хэмжээ** | | | | | | | | % | % | % |
| **80100** | **Үндсэн үйл ажиллагаа** | **36,286,805.7** | **49,530,423.0** | **49,530,423.0** | **68,415,106.9** | **88,939,638.9** | **115,621,530.6** | 73.3 | 100.0 | 72.4 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 36,286,805.7 | 49,530,423.0 | 49,530,423.0 | 68,415,106.9 | 88,939,638.9 | 115,621,530.6 | 73.3 | 100.0 | 72.4 |
| **НИЙТ, Зардлын зориулалт -арга хэмжээ *** | | MNT 36,286,805.7 | MNT 49,530,423.0 | MNT 49,530,423.0 | MNT 68,415,106.9 | MNT 88,939,638.9 | MNT 115,621,530.6 | | | |
| **В. Санхүүжүүлэх эх үүсвэр** | | | | | | | | % | % | % |
| 31 | Улсын төсөв | 42,592,667.0 | 53,765,579.1 | 53,152,508.8 | 81,699,854.0 | 106,577,954.4 | 138,919,484.8 | 79.2 | 101.2 | 65.1 |
| 310003 | ЗГ-ын тусгай сан | | | | | | | % | % | % |
| 310002 | Тусгай зориулалтын шилжүүлэг | | | | | | | % | % | % |
| 32 | Орон нутгийн төсөв | | | | | | | % | % | % |
| 33 | Нийгмийн даатгалын сан | | | | | | | % | % | % |
| 35 | Үйл ажиллагааны орлого | 1,453,487.2 | 1,227,147.2 | 1,227,147.2 | 1,227,147.2 | 1,227,147.2 | 1,227,147.2 | 118 | 100 | 100.0 |
| 36 | Тусламж | | | | | | | % | % | % |
| 37 | Бусад эх үүсвэр | | | | | | | % | % | % |
| **НИЙТ, Эх үүсвэр** | | MNT 44,046,154.2 | MNT 54,992,726.3 | MNT 54,379,656.0 | MNT 82,927,001.2 | MNT 107,805,101.6 | MNT 140,146,632.0 | | | |

**Г.Хөтөлбөрийн орон тооны мэдээлэл**

| | .1. | .2. | .3. | .4. | .5. | .6. | .7. | .8. | .9. |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | - | - | - | - | | | 0 | 0 | 0 |
| 2.Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 1,245.0 | 1,253.0 | 1,253.0 | 1,452.0 | 1,603.0 | 1,702.0 | 99.4 | 100.0 | 86.3 |
| 3.Ажлын албаны албан хаагч (АА) | # | # | # | # | # | # | | | |
| 4.СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | # | # | # | # | # | # | | | |
| 5.ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | # | # | # | # | # | # | | | |
| 6.Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | # | # | # | # | # | # | | | |
| 7.Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | # | # | # | # | # | # | | | |
| 8.Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | # | # | # | # | # | # | | | |

**Томилолт, зочны зардал:** Гаалийн байгууллага нь харьяа гаалийн газар хороодод хяналт шалгалт хийх, дотоод аудит болон бусад боомтын үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор албан томилолтоор ажилладаг ба 2017 оны 7 дугаар сарын 1 өдрөөс зөрчлийн тухай хуулийн хэрэгжиж эхлэсэнтэй холбогдуулан дотоод томилолтын зардал өссөн. Мөн гаалийн шинэчлэлийн хүрээнд харьяа боомтууд дээр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлууд, төсөл хөтөлбөрүүдийн бүтээн байгуулалтын ажлын явцтай тухайн боомт дээр очиж танилцах, хяналт тавих зайлшгүй шаардлага үүсч байгаа тул тус зардлыг нэмэгдүүлж төсөвлөсөн.

**Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж:**
1. Гаалийн мэдээллийн нэгдсэн системийн шинэчлэлийн хүрээнд Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлэн худалдан авсан тоног төхөөрөмж, програм хангамжийн албан ёсны ашиглалтын эрх бүхий лицензийн төлбөр;
2. Байгууллагын дотоод албан хэрэг хөтлөлтийг сайжруулах зорилгоор програм хангамжийн албан ёсны ашиглалтын эрх бүхий лицензийн төлбөр;
3.Гаалийн лабораторийг олон улсын итгэмжлэлд хамруулах олон улсын зөвлөх үйлчилгээний багтай 2020 онд байгуулсан гэрээний хэрэгжилт Ковид-19 цар тахалтай холбогдуулан удааширч, гэрээний хугацааг сунгахаар болсон тул үлдэгдэл төлбөр;
4. Гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглагддаг нэг удаагийн троссон ломбоны худалдан авалтыг 2021 онд зохион байгуулаагүй тул уг зардалыг тооцож тус тус нэмж төсөвлөсөн.

**Бараа үйлчилгээний бусад зардал:** Гаалийн шинэчлэлтэй холбоотой Гашуунсухайт, Бичигт боомтуудыг түр горимд нүүлгэн шилжүүлэх, мөн бүтээн байгуулалттай холбоотой түр горимд гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагаа зохион байгуулж буй Замын-Үүд боомтын нүүлгэн шилжүүлэх зардлыг тус тус тооцон төсөвлөсөн. Мөн Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2-д заасны дагуу тухайн жилийн төсвийн 1%-ийг төлөвлөж зарцуулна гэсэн заалтын дагуу зардлыг тусгасан. Гаалийн байгууллага нь Дэлхийн гаалийн байгууллагын гишүүн орон тул уулзалт хурал зөвлөгөөн болон зочин төлөөгчийг хүлээн авах зайлшгүй шаардлага гардаг тул гадаад арга хэмжээтэй холбоотой зардлыг нэмж төсөвлөсөн. Гадаад албан томилолт болон зочин төлөөлөгч хүлээн авах зардлын төсвийг Сангийн яамнаас олгохгүй байгаа.

**Дээж худалдан авах:** Гаалийн төв лабораторийн шинжилгээний тоо нэмэгдсэн мөн шинээр ашиглалтад орсон салбар лабораториудын шинжилгээний урвалж бодис, шинжилгээний шил савны зардлыг тооцож төсөвлөсөн.

**Засгийг газрын гадаад шилжүүлэг:** Гаалийн байгууллага нь Дэлхийн гаалийн байгууллагын гишүүн орон тул жил бүр гишүүнчлэлийн татвар 27,000 евро төлдөг. Уг зардал валютын ханшны өсөлтөөс шалтгаалж өссөн болно.

## ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

| Дугаар | Аймаг, нийслэл | Сум дүүрэг | Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хэмжих нэгж | Хүчин чадал | Обьектын төрөл | Обьектын ангилал | Хугацаа | | Төслийн төсөвт өртөг онуудад /сая.төг/ | | | | Санхүүжилт /сая.төг/ | | | | Нийт авсан санхүүжилт | Байгууллагын санал | | Он дамжин хэрэгжих бол дараагийн жилийн санхүүжилт | Төсвийн ерөнхийлөн захирагч |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Эхлэх | Дуусах | Тухайн төсөл хэрэгжиж эхэлсэн оноос төлөвлөж буй он хүртэлх жил бүрийн төсөвт өртөг | | | | Тухайн төсөл хэрэгжиж эхэлсэн оноос төлөвлөж буй он хүртэлх жил бүрийн санхүүжсэн дүн | | | | | Төсвийн төсөлд тусгах төсөвт өртөг /сая.төг/ | Төсвийн төсөлд тусгах санхүүжих дүн /сая.төг/ | | |
| | | | | | | | | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2019 | 2020 | 2021 | 2022 | | | | | |
| | | | **I.Барилга байгууламж** | | | | | | | | - | - | **62,240.0** | - | **3,000.0** | **2,500.0** | **62,240.0** | **5,500.0** | **62,240.0** | **62,240.0** | | |
| | | | Шинэ | | | | | | | | - | - | 62,240.0 | - | 3,000.0 | 2,500.0 | 62,240.0 | 5,500.0 | 62,240.0 | 62,240.0 | | |
| 1 | Улаанбаатар | Гаалийн ерөнхий газар | Хилийн зарим боомтуудыг шилэн кабельд холбох | км | 465 | Шилэн кабель | Барилга байгууламж | 2020 | 2022 | | | | 5,340.0 | | 3,000.0 | 2,500.0 | 5,340.0 | 5,500.0 | 5,340.0 | 5,340.0 | | Сангийн сайд |
| 2 | Улаанбаатар | Гаалийн ерөнхий газар | Ажилчдын орон сууцны барилга /260 айлын орон сууц/ | м2 | 19840 | Орон сууцны барилга | Барилга байгууламж | 2022 | 2022 | | | | 26,100.0 | | | | 26,100.0 | | 26,100.0 | 26,100.0 | | Сангийн сайд |
| 3 | Улаанбаатар | Улаанбаатар хот дахь гаалийн газар | Улсын орлогын барааны зориулалтын агуулах | м2 | 720 | Агуулахын барилга | Барилга байгууламж | 2022 | 2022 | | | | 1,800.0 | | | | 1,800.0 | | 1,800.0 | 1,800.0 | | Сангийн сайд |
| 4 | Дархан-Уул | Дархан-Уул аймаг дахь гаалийн газар | Салбар лаборатори | м2 | 504 | Лабораторийн барилга | Барилга байгууламж | 2022 | 2022 | | | | 1,500.0 | | | | 1,500.0 | | 1,500.0 | 1,500.0 | | Сангийн сайд |
| 5 | Дархан-Уул | Дархан-Уул аймаг дахь гаалийн газар | Ажилчдын орон сууцны барилга /60 айл/ | м2 | 4200 | Орон сууцны барилга | Барилга байгууламж | 2022 | 2022 | | | | 6,000.0 | | | | 6,000.0 | | 6,000.0 | 6,000.0 | | Сангийн сайд |
| 6 | Дорноговь | Замын-Үүд дэх гаалийн газар | Ажилчдын орон сууцны барилга /32 айл/ | м2 | 2340 | Орон сууцны барилга | Барилга байгууламж | 2022 | 2022 | | | | 3,100.0 | | | | 3,100.0 | | 3,100.0 | 3,100.0 | | Сангийн сайд |
| 7 | Дорноговь | Замын-Үүд дэх гаалийн газар | Салбар лаборатори худалдаж авах | м2 | 270 | Лабораторийн барилга | Барилга байгууламж | 2022 | 2022 | | | | 300.0 | | | | 300.0 | | 300.0 | 300.0 | | Сангийн сайд |
| 8 | Дорноговь | Сайншанд дахь гаалийн газар | Ажилчдын орон сууцны барилга /32 айл/ | м2 | 2340 | Орон сууцны барилга | Барилга байгууламж | 2022 | 2022 | | | | 3,100.0 | | | | 3,100.0 | | 3,100.0 | 3,100.0 | | Сангийн сайд |
| 9 | Сэлэнгэ | Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар | Ажилчдын орон сууцны барилга /72 айлын 10 давхар/ | м2 | 4320 | Орон сууцны барилга | Барилга байгууламж | 2022 | 2022 | | | | 7,100.0 | | | | 7,100.0 | | 7,100.0 | 7,100.0 | | Сангийн сайд |
| 10 | Хөвсгөл | Ханх дахь гаалийн хороо | Баруун бүсийн сургалтын төвийн цогцолбор | га | 3.7 | Сургалтын төвийн барилга | Барилга байгууламж | 2022 | 2022 | | | | 1,300.0 | | | | 1,300.0 | | 1,300.0 | 1,300.0 | | Сангийн сайд |
| 11 | Хөвсгөл | Ханх дахь гаалийн хороо | Албан конторын барилга шинээр барих | м2 | 1200 | Конторын барилга | Барилга байгууламж | 2022 | 2022 | | | | 1,500.0 | | | | 1,500.0 | | 1,500.0 | 1,500.0 | | Сангийн сайд |
| 12 | Увс | Увс аймаг дахь гаалийн газар | Албан конторын барилга шинээр барих | м2 | 1200 | Конторын барилга | Барилга байгууламж | 2022 | 2022 | | | | 2,000.0 | | | | 2,000.0 | | 2,000.0 | 2,000.0 | | Сангийн сайд |
| 13 | Өмнөговь | Гашуунсухайт дахь гаалийн газар | Оюутолгой гаалийн хяналтын бүсийн албан хаагчдын орон сууцны барилга шинээр барих /Ханбогд сум/ /32 айл/ | м2 | 2340 | Орон сууцны барилга | Барилга байгууламж | 2022 | 2022 | | | | 3,100.0 | | | | 3,100.0 | | 3,100.0 | 3,100.0 | | Сангийн сайд |
| | | | **II.Их засвар** | | | | | | | | - | - | **5,623.5** | - | - | - | **5,623.5** | - | **5,623.5** | **5,623.5** | | |
| | | | Шинэ | | | | | | | - | - | - | 5,623.5 | - | - | - | 5,623.5 | - | 5,623.5 | 5,623.5 | | Сангийн сайд |
| 1 | Улаанбаатар | Улаанбаатар хот дахь гаалийн газар | Гадна фасад, барилгын их засвар | м2 | 1861 | Конторын барилга | Их засвар | 2022 | 2022 | | | | 960.0 | | | | 960.0 | | 960.0 | 960.0 | | Сангийн сайд |
| 2 | Улаанбаатар | Улаанбаатар хот дахь гаалийн газар | Лифт шинээр солих | ширхэг | 2 | Конторын барилга | Их засвар | 2022 | 2022 | | | | 200.0 | | | | 200.0 | | 200.0 | 200.0 | | Сангийн сайд |
| 3 | Дархан-Уул | Дархан-Уул аймаг дахь гаалийн газар | Барилгын дээвэр, гадна фасад, их засвар | м2 | 1128 | Конторын барилга | Их засвар | 2022 | 2022 | | | | 450.0 | | | | 450.0 | | 450.0 | 450.0 | | Сангийн сайд |
| 4 | Дорноговь | Замын-Үүд дэх гаалийн газар | Ажилчдын орон сууцны барилгын дээвэр, гадна фасад, цэвэр, бохир ус, дулааны шугамын засвар | айл | 92 | Дэд бүтэц | Их засвар | 2022 | 2022 | | | | 740.0 | | | | 740.0 | | 740.0 | 740.0 | | Сангийн сайд |
| 5 | Баян-Өлгий | Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар | Албан конторын барилгын өргөтгөл /Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар/ | м2 | 186 | Конторын барилга | Их засвар | 2022 | 2022 | | | | 800.0 | | | | 800.0 | | 800.0 | 800.0 | | Сангийн сайд |
| 6 | Сэлэнгэ | Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар | Гаалийн ажилчдын орон сууцны их засвар | иж бүрдэл | 1 | Орон сууц | Их засвар | 2022 | 2022 | | | | 773.5 | | | | 773.5 | | 773.5 | 773.5 | | Сангийн сайд |
| 7 | Улаанбаатар | Гаалийн ерөнхий газар | Горхи мэлхий хад амралтын газрын өргөтгөл шинэчлэлт /Сангийн яам, гааль, татвар/ | м2 | - | Өргөтгөл, шинэчлэл | Их засвар | 2022 | 2022 | | | | 1,500.0 | | | | 1,500.0 | | 1,500.0 | 1,500.0 | | Сангийн сайд |
| 8 | Увс | Увс аймаг дахь гаалийн газар | Албан хаагчдын орон сууцны их засвар | ширхэг | 1 | Орон сууц | Их засвар | 2022 | 2022 | | | | 200.0 | | | | 200.0 | | 200.0 | 200.0 | | Сангийн сайд |
| | | | **III.Тоног төхөөрөмж** | | | | | | | **32,470.0** | **22,475.7** | - | **62,858.3** | **5,004.7** | **20,207.6** | **25,288.6** | **62,858.3** | **41,205.7** | **62,858.3** | **62,858.3** | | |
| | | | Шинэ | | | | | | | 32,470.0 | 22,475.7 | - | 62,858.3 | 5,004.7 | 20,207.6 | 25,288.6 | 62,858.3 | 41,205.7 | 62,858.3 | 62,858.3 | | |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Улаанбаатар | Гаалийн ерөнхий газар | Дээж авах тоног төхөөрөмж | иж бүрдэл | 7 | Лабораторийн тоног төхөөрөмж | Тоног төхөөрөмж | 2019 | 2022 | 14,300.0 | | | 11,473.3 | 5,004.7 | | 9,295.2 | 11,473.3 | 5,004.7 | 11,473.3 | 11,473.3 | 4,057.0 | Сангийн сайд |
| 2 | Улаанбаатар | Гаалийн ерөнхий газар | Лабораторийн тоног төхөөрөмж | иж бүрдэл | 5 | Лабораторийн тоног төхөөрөмж | Тоног төхөөрөмж | 2020 | 2022 | | 19,953.0 | | 10,085.0 | | 12,793.7 | 7,159.3 | 10,085.0 | 19,953.0 | 10,085.0 | 10,085.0 | 10,085.0 | Сангийн сайд |
| 3 | Улаанбаатар | Гаалийн ерөнхий газар | Ухаалаг гарц иж бүрдэл төхөөрөмж, дэд бүтцийн хамт | иж бүрдэл | 4 | Гаалийн хяналт шалгалтад ашиглах | Тоног төхөөрөмж | 2019 | 2022 | 5,450.0 | 2,522.7 | | 17,300.0 | | 2,728.0 | 800.0 | 17,300.0 | 3,528.0 | 17,300.0 | 17,300.0 | 17,300.0 | Сангийн сайд |
| 4 | Улаанбаатар | Гаалийн ерөнхий газар | Чингэлэг шалгах рентген төхөөрөмж, дэд бүтцийн хамт | ширхэг | 14 | Гаалийн хяналт шалгалтад ашиглах | Тоног төхөөрөмж | 2019 | 2022 | 12,720.0 | | | 21,500.0 | | 4,685.9 | 8,034.1 | 21,500.0 | 12,720.0 | 21,500.0 | 21,500.0 | | Сангийн сайд |
| 5 | Улаанбаатар | Гаалийн ерөнхий газар | Гаалийн газар, хороодын автомашины парк шинэчлэлт | ширхэг | 19 | Автомашин | Тоног төхөөрөмж | 2022 | 2022 | | | | 2,500.0 | | | | 2,500.0 | | 2,500.0 | 2,500.0 | | Сангийн сайд |
| | | | **IV.ТЭЗҮ** | | | | | | | | | | **500.0** | - | - | - | **500.0** | - | **500.0** | **500.0** | | |
| | | | **Шинэ** | | | | | | | | | | 500.0 | | | | 500.0 | | | | | |
| 1 | Улаанбаатар | Гаалийн ерөнхий газар | Ажилчдын орон сууцны барилга /260 айлын орон сууц/ | ширхэг | 1 | Орон сууцны барилга | Зураг төсөл | 2022 | 2022 | | | | 180.0 | | | | 180.0 | | 180.0 | 180.0 | | Сангийн сайд |
| 2 | Улаанбаатар | Гаалийн ерөнхий газар | Ажилчдын орон сууцны барилга /60 айлын орон сууц/ | ширхэг | 1 | Орон сууцны барилга | Зураг төсөл | 2022 | 2022 | | | | 120.0 | | | | 120.0 | | 120.0 | 120.0 | | Сангийн сайд |
| 3 | Улаанбаатар | Гаалийн ерөнхий газар | Ажилчдын орон сууцны барилга /32 айлын орон сууц/ | ширхэг | 1 | Орон сууцны барилга | Зураг төсөл | 2022 | 2022 | | | | 100.0 | | | | 100.0 | | 100.0 | 100.0 | | Сангийн сайд |
| 4 | Улаанбаатар | Улаанбаатар хот дахь гаалийн газар | Улсын орлогын барааны зориулалтын агуулах | ширхэг | 1 | Агуулахын барилга | Зураг төсөл | 2022 | 2022 | | | | 100.0 | | | | 100.0 | | 100.0 | 100.0 | | Сангийн сайд |
| | | | **НИЙТ** | | | | | | | **32,470.0** | **22,475.7** | - | **131,221.8** | **5,004.7** | **23,207.6** | **27,788.6** | **131,221.8** | **46,705.7** | **131,221.8** | **131,221.8** | - | - |